



**Шинээр гэрчилгээ авч буй байгууллагуудад материал бүрдүүлэхэд анхаарах зүйлсийн зөвлөмж:**

1. Хүсэлт гаргасан албан бичиг
  - Огноо, дугаар байх
  - Компаний үйл ажиллагааны товч танилцуулга
  - Ямар төрлийн гэрчилгээ авах гэж байгааг тодорхой бичнэ
  - Хавсралт хэдэн хуудас материал байгааг бичнэ.
  - Байгууллагын логотой албан бланк дээр гаргана.
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
  - Аялал жуулчлал эрхлэх тэмдэглэл
  - Захирал томилсон тэмдэглэл хийгдсэн байх
  - Нэр өөрчлөгдсөн тэмдэглэл
3. Захирлын иргэний үнэмлэхний хуулбар заавал байх
4. Байгууллагын товч анкет бөглөхдөө
  - Монгол, англи дээр нэрийг тодорхой бичих
  - Вебсайт заавал байх
  - Аяллын зах зээлийг тодорхой бичих
  - Тур операторын ангиллыг сонголтыг тэмдэглэх
  - Хөрөнгө оруулалтын гадаад дотоод аль нь болохыг бичих
  - Гарын үсэг, тамга дарагдсан байх
5. Ажилтаны анкет
  - Ажилтаны зураг
  - Ажилтаны гарын үсэг
  - Анкет доторх мэдээлэл үнэн зөв гүйцэд бөглөх
  - 2 ажилтаны нэг нь заавал аялал жуулчлалын менежментийн бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй байх
6. Ажилтаны диплом, сертификатын хуулбар
7. Ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хуулбар
8. Ажлын байрны түрээсийн гэрээ, үл хөдлөх гэрчилгээний хуулбар
9. Бизнес төлөвлөгөө
  - Компаний танилцуулга
  - Зах зээлийн судалгаа
  - Аяллын маршрут, үнийн судалгаа
10. Хураамж тушаасан баримтын хуулбар
11. Хөдөө орон нутгийн компани тухайн орон нутгийн ЗДТГ-ын АЖ-ын мэргэжилтнээс тодорхойлолт авсан байна.



## Сунгалт хийлгэх байгууллагын материал авахад анхаарах зүйл:

1. Хүсэлт гаргасан албан бичиг
  - Компаний үйл ажиллагааны товч танилцуулга
  - Ямар төрлийн гэрчилгээ, дугаар, огноог тодорхой бичнэ
  - Хавсралт хэдэн хуудас материал байгааг бичнэ.
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
  - Аялал жуулчлал эрхлэх тэмдэглэл
  - Захирал томилсон тэмдэглэл байгааг шалгаж авах
  - Нэр өөрчлөгдсөн тэмдэглэл
3. Байгууллагын товч анкет бөглөхдөө
  - Монгол, англи дээр нэрийг тодорхой бичих
  - Ангиллын гэрчилгээний дугаар, огноог бичих
  - УБГ дээрх хаяг, одоогийн хаяг бичих
  - Вебсайт заавал байх
  - Аяллын зах зээл
  - Тур операторын ангиллын гэрчилгээний дугаар
  - Хөрөнгө оруулалтын хувь бичнэ
  - Зэрэглэлтэй хөтчийн тоо /үндсэн, гэрээт/
  - Мэргэшсэн жолоочийн тоо /үндсэн, гэрээт/
  - Аймаг орон нутагт илгээсэн жуулчдын тоо
  - Хөдөө орон нутагт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ
  - Гарын үсэг, тамга дарагдсан байна.
  -
4. АЖ-1 маягт
  - Ирсэн жуулчдын тоо, явуулсан жуулчдын тоо
  - Аль орноос жуулчин авснаа тэмдэгдэх
  - Хэдэн аялал зохион байгуулсан тоогоо бичих
  - 
  - Бусад гэсэн хэсэгт ямар орныг заавал бичнэ.
  - Орлого, зарлага, ашиг алдагдал, хөрөнгө хуримтлал
  - Гарын үсэг, тамга
5. Ангиллын гэрчилгээ өмнөх оных эх хувиараа
6. Хураамж тушаасан баримтын хуулбар